



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭРДЭНЭХУЯГ ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-майл: khuvs gul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: <http://umch.khs.gov.mn>

2019.02.19 № 1/71  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Танай байгууллагын 2018 оны 1028 тоот хүсэлтийн дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх (дэлгүүр) аж ахуй нэгжийг сонгох ХӨАХХҮГазар/201912001 дугаартай худалдан авах ажиллагааг захиалагчийн ирүүлсэн ажлын даалгаврын дагуу 46 багц болгон зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад доор дурьдсан танилцуулга зөвлөмжийг хүргүүллээ. Уг тендерийг төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр зарлаж, гүйцэтгэгчийг сонгосон тухай үнэлгээний хорооны шийдвэр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх (дэлгүүр) аж ахуй нэгжийг сонгох тендер шалгаруулалтын 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 12, 13, 18, 19, 21, 22, 23, 24, 25, 28, 30, 34, 35, 36, 37, 39, 40, 42, 43, 44, 45, 46 дугаар багцуудад гүйцэтгэгч шалгарсан тул хавсралтад дурьдсан нэр бүхий аж ахуйн нэгжүүдтэй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна. Мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.4.2 дахь заалтын дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэний дараа гэрээ байгуулж ажиллана уу.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх (дэлгүүр) аж ахуй нэгжийг сонгох тендер шалгаруулалтын 7, 8, 14, 15, 16, 17, 20, 26, 27, 29, 31, 32, 33, 38, 41 дүгээр багцын тендер шалгаруулалт амжилтгүй болж, Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр дахин зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулна.

Тендер шалгаруулалтын үнэлгээ болон гэрээ байгуулах багцуудыг хавсралтаар хүргүүлэв.

Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа дараах зүйлийг анхаарна уу.

d/A4

890892100

1. Шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хуулийн хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл хүргүүлэх,
2. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах,
3. Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон барааны нэгжийн үнэ өөрчлөгдөхгүй байхаар бараа нийлүүлэлтийн хуваарьт тусгаж, нийт үнээр гэрээ байгуулна.
4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайт болон орон нутгийн цахим сайтад тендер шалгаруулалтын ерөнхий мэдээллийг тендер нээсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор байршуулах,
5. Гэрээ байгуулахад оролцсон төрийн албан хаагчдаас “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бөглөж Авлигатай тэмцэх газрын сайтад шивж оруулах,
6. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэх,
7. Санхүүжилтийн хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, бараа бүрийн техникийн тодорхойлолтыг захиалагч, гүйцэтгэгчээр баталгаажуулж гэрээнд хавсаргах,
8. Тус газраас хүргэсэн дараах маягтууд, тендерийн баримт бичиг болон бусад материалыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.2-т заасны дагуу архивын нэгж болгон хадгалах. Үүнд:
  - Захиалагчаас боловсруулсан тендерийн баримт бичиг
  - Тендерийн нээлтийн тэмдэглэл
  - Үнэлгээний хорооны гишүүдээс авсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”
  - Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтүүд
  - Үнэлгээний хүснэгтээр гаргасан тендерийн үнэлгээ
  - Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг
  - Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтаас хэвлэсэн тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээлэл
  - Үнэлгээний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө
  - Шалгарсан болон шалгараагүй оролцогчид хүргэх мэдэгдэл (төсөл хэлбэрээр)
9. Тендер шалгаруулалт гэрээлэх ажиллагааны үр дүнг [www.umch.khs.gov.mn](http://www.umch.khs.gov.mn) болон байгууллагынхаа сайтад гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоногийн дотор нийтлэх.
10. Гэрээний эх хувь болон мэдэгдлийн хуулбар хувийг гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор манай газарт ирүүлэх.
11. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд: Гэрээний нэр, үнэ, өртөг, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулсны дараа гүйцэтгэгчид санхүүжилт олгох тухай зааж өгөх.

Хавсралт ... хуудас.

ДАРГА



Б.БОЛД

Орон нутгийн өмчийн газрын даргын 2019 оны 2 дугаар 19-ний өдрийн 1171-дүгээр албан тоотын хавсралт

№	Балц дугаар	Сумын нэр	Баг	Шалгарсан оролцогчийн нэр	Гэрээ байгуулах дүн	Оролцогчийн тоо	Шалгараагүй оролцогчийн нэр	Шалгараагүй үндэслэл			Дахин зарлах эсэх	
								Шалгараагүй шалгаан	Тендерийн баримт бичигт заасан шаардлага	Тендерээс татгалзсан хуулийн үндэслэл		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	1	Мөрөн	1	Хөвсгөл тэвхэн ХХК	50 112 000	1						
2	2	Мөрөн	2	Тэвхэн мандал ХХК	33 024 000	1						
3	3	Мөрөн	3	Тэвхэн мандал ХХК	37 056 000	2	Худагийн эх ХХК	ХХҮГ-ын 2019.01.08-ны өдрийн 24 тоот албан бичгээр 2018 онд ХЭБ-ээр үйлчилгээ үзүүлсэн үнэлгээгээр 70-с доош оноогоор үнэлэгдсэн бол хангалтгүй гэж тендерээс татгалзах саналыг ирүүлсэн. Худагийн эх ХХК 63.75 оноо авсан.			Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтыг хангаагүй тул мөн хуулийн 27-р зүйлийн 27.4 дэх заалтын дагуу татгалзав.	
4	4	Мөрөн	4	Хөвсгөл тэвхэн ХХК	78 528 000	2	Жанст ундрам ХХК	444629 төгрөгийн ХХОАТ-ын өртэй цахим тодорхойлолтыг тендэрт ирүүлсэн			Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	
5	5	Мөрөн	5	Жугнай бат ХХК	33 792 000	1						
6	6	Мөрөн	6	Зүүн хөөнгө ХХК	22 550 200	1						
7	7	Мөрөн	7	Шалгараагүй	-	0						Тийм
8	8	Мөрөн	7	Шалгараагүй	-	0						Тийм
9	9	Мөрөн	8	Хөвсгөл тэвхэн ХХК	13 440 000	1						
10	10	Мөрөн	9	харцат салбарт хоршоо	45 984 000	1						
11	11	Мөрөн	9	харцат салбарт хоршоо	45 984 000	1						

12	12	Мөрөн	10	Очир хайрхан уул ХХК	65 568 000	2	Өндөр түвшин мандал ХХК	Өндөр түвшин ман ХХК-ийн ирүүлсэн нэгж үнийн саналын арифметик дундаж нь шалгарсан оролцогчийн нэгж үнийн саналын арифметик дунджаас өндөр байсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28-р зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав	
13	13	Мөрөн	10	Арбэл булаг хоршоо	65 568 000	1			Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг дагуу татгалзав.	
14	14	Мөрөн	11	Шалгараагүй		2	Жугнай бат ХХК	Тендерийн баталгаа ирүүлээгүй	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг дагуу татгалзав.	Тийм
15	15	Мөрөн	11	Шалгараагүй		2	Түнэл тэрхэн цагаан уул ХХК	Тендерт оролцогчийн үнийн санал баталсан төсвөөс зөрүүтэй, үнийн саналыг 70,613,900 төгрөг буюу баталсан төсвөөс 3,114,100 төгрөгөөр зөрүүтэй.	Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-н 35.3 (д)- д. "Захиалагчийн баталсан төсөвт өртгөөс өндөр буюу бага нийт үнэ санал болгосон бол тендерээс татгалзах үндэслэл болно" гэж заасан.	Тийм
16	15	Мөрөн	12	Шалгараагүй	-	0				Тийм
17	16	Мөрөн	13	Шалгараагүй	-	0				Тийм
18	17	Мөрөн	13	Шалгараагүй	-	0				Тийм
19	18	Мөрөн	14	Өндөр түвшин мандал ХХК	57 552 000	2	Хөвсгөл барс ХХК	Хөвсгөл барс ХХК-ийн ирүүлсэн нэгж үнийн саналын арифметик дундаж нь шалгарсан оролцогчийн нэгж үнийн саналын арифметик дунджаас өндөр байсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28-р зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав	
20	19	Мөрөн	14	Хөвсгөл барс ХХК	57 552 000	1				

21	20	Алаг-Эрдэнэ		Хөвсгөл идэр энд ХХК			2	Гялаадын эх ХХК	Гялаадын эх ХХК- ирүүлсэн нэгж үнийн, саналын арифметик дундаж нь шалгарсан оролцогчийн нэгж үнийн саналын арифметик дунджаас өндөр байсан.		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28-р зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав
23	21	Алаг-Эрдэнэ		Гялаадын эх ХХК	37 344 000	1					
24	22	Хатгал		Хатгал цагаан чулуут ХХК	57 408 000	1					
25	23	Арбулаг		Мянган хоньт ХХК	56 640 000	1					
26	24	Баянзүрх		Ням дэвшил ХХК	63 340 000	1					
27	25	Бүрэнгогтох		Хос баян хайрхан хоршоо	68 160 000	1					
28								Өөдлөх галт ХХК	Санал болгож буй мах махан бүтээгдэхүүний нэгж үнэ харьцангуй бага тул татгалзав.	Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-н 35.3 (б)- д: "Тендерт оролцогчийн санал болгосон барааны нэгж үнэ нь тухайн орон нутгийн зах зээлийн үнээс бага бол тендерээс татгалзах үндэслэл болно." гэж заасан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.
29	26	Галт		Шалгараагүй		2		Их харгана ундраа ХХК	Санал болгож буй мах махан бүтээгдэхүүний нэгж үнэ харьцангуй бага тул татгалзав.	Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-н 35.3 (б)- д: "Тендерт оролцогчийн санал болгосон барааны нэгж үнэ нь тухайн орон нутгийн зах зээлийн үнээс бага бол тендерээс татгалзах үндэслэл болно." гэж заасан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.
30								Загал хайрхан ХХК	Тендерт оролцогчийн үнийн санал баталсан төсвөөс зөрүүтэй, үнийн саналыг 81,990,000 төгрөг буюу баталсан төсвөөс 378,000 төгрөгөөр зөрүүтэй.	Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-н 35.3 (д)- д: "Захиалагчийн баталсан төсөвт өртгөөс өндөр буюу бага нийт үнэ санал болгосон бол тендерээс татгалзах үндэслэл болно" гэж заасан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.

31	27	Жаргалант	Шалгараагүй	3	Түсэгийн булаг ХХК	ХХҮГ-ын 2019.01.ны өдрийн 24 тоот албан бичгээр 2018 онд ХЭБ-ээр үйлчилгээ үзүүлсэн үнэлгээгээр 70-с доош оноогоор үнэлэгдсэн бол хангалтгүй гэж тендерээс татгалзах саналыг ирүүлсэн. Тосон хүрдэт ХХК 58,75 оноо авсан.	ХХҮГ-ын 2019.01.ны өдрийн 24 тоот албан бичгээр 2018 онд ХЭБ-ээр үйлчилгээ үзүүлсэн үнэлгээгээр 70-с доош оноогоор үнэлэгдсэн бол хангалтгүй гэж тендерээс татгалзах саналыг ирүүлсэн. Тосон хүрдэт ХХК 58,75 оноо авсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтыг хангаагүй тул татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15-р зүйлийн 15.3.4, 16-р зүйлийн 16.1.1, 16.1.2, 16.1.4, 27-р зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалтыг тус тус хангаагүй тул мөн хуулийн 27-р зүйлийн 27.4 дэх заалтын дагуу татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	Тийм
32					Дэвжид хангайн хишиг ХХК	Санал болгож буй мах, махан бүтээгдэхүүний нэгж үнэ харьцангуй бага тул татгалзав.	Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-н 35.3 (б)-д: "Тендерт оролцогчийн санал болгосон барааны нэгж үнэ нь тухайн орон нутгийн зах зээлийн үнээс бага бол тендерээс татгалзах үндэслэл болно." гэж заасан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15-р зүйлийн 15.3.4, 16-р зүйлийн 16.1.1, 16.1.2, 16.1.4, 27-р зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалтыг тус тус хангаагүй тул мөн хуулийн 27-р зүйлийн 27.4 дэх заалтын дагуу татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	Тийм	
33	28	Их-Уул	Буянт дөрөө нуур хоршоо	2	Сорлог хангай ХХК	Нийт үнийн санал, нэгж үнийн санал, барааны техникийн тодорхойлолт болон захиалагчийн баталсан тендерийн баримт бичигт заасан бусад иж бүрдлийг ирүүлээгүй	Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-н 18.1 (в), (г2), (г3), 19.1 (б), (в), (г)-д заасан тендерийн үнэлгээнд шаардлагатай баримт бичгийг ирүүлээгүй.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15-р зүйлийн 15.3.4, 16-р зүйлийн 16.1.1, 16.1.2, 16.1.4, 27-р зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалтыг тус тус хангаагүй тул мөн хуулийн 27-р зүйлийн 27.4 дэх заалтын дагуу татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	Тийм		
34	29	Рашаант	Шалгараагүй	2	Өрөлт ХХК	122600 төгрөгийн ХХОАТ-ын өртэй цахим тодорхойлолтыг тендерт ирүүлсэн	122600 төгрөгийн ХХОАТ-ын өртэй цахим тодорхойлолтыг тендерт ирүүлсэн	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	Тийм	



40					Итгэл зүтгэл хоршоо	10,6 сая төгрөгийн татварын өртэй цахим тодохойллыг тендэрт ирүүлсэн		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	
41					Мөнх тэмүүлэн мөрөн ХХК	53599 төгрөгийн ХХОАТ-ын өртэй цахим тодорхойлолтыг тендэрт ирүүлсэн		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	
42	33	Тариалан	Шалгараагүй	3	Мөнх нөөлөг ХХК	Барааны техникийн тодорхойлолт болон захивалачийн баталсан тендерийн баримт бичигт заасан бусад иж бүрдлийг ирүүлээгүй	Тендерийн баримт бичгийн ТООЗ-н 18.1 (в), (г2), (г3), 19.1 (б), (в), (г)-д заасан тендерийн үнэлгээнд шаардлагатай баримт бичгийг ирүүлээгүй.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15-р зүйлийн 15.3.4, 16-р зүйлийн 16.1.1, 16.1.2, 16.1.4, 27-р зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалтыг тус тус хангаагүй тул мөн хуулийн 27-р зүйлийн 27.4 дэх заалтын дагуу татгалзав.	Тийм
43					Итгэл зүтгэл хоршоо	10,6 сая төгрөгийн татварын өртэй цахим тодохойллыг тендэрт ирүүлсэн		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.	



44	34	Тосонцэнгэл		Намуун мөрөн ХХК	57 216 000	2	Тосон хүрдэт ХХК	ХХҮГ-ын 2019.01.01-ны өдрийн 24 тоот албан бичгээр 2018 онд ХЭБ-ээр үйлчилгээ үзүүлсэн үнэлгээгээр 70-с доош оноогоор үнэлэгдсэн бол хангалтгүй гэж тендерээс татгалзах саналыг ирүүлсэн. Тосон хүрдэт ХХК 57,5 оноо авсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтыг хангаагүй тул татгалзав.
45	35	Төмөрбулаг		Хур бороо ХХК	32 544 000	1			
46	36	Төмөрбулаг		Нарлаг цэнхэр далай ХХК	32 544 000	1			
47	37	Түнэл		Тулах эрдэнэ ХХК	90 336 000	1			
48							Буянт шишгэд ХХК	1,5 сая төгрөгийн татварын өртэй цахим тодохойлолтыг тендерт ирүүлсэн	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу татгалзав.
49	38	Улаан-Уул		Шалгараагүй		2	Өндөр өвөр ХХК	Тендерт оролцогчийн үнийн санал баталсан төсвөөс зөрүүтэй, үнийн саналыг 65,999 600 төгрөг буюу баталсан төсвөөс 1,296,400 төгрөгөөр зөрүүтэй.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.
50	39	Ханх		Усан туул ХХК	74 688 000	1			
51	40	Цагааннуур		Уулам зх ХХК	48 384 000	3	Хоймор сүмбэр эрдэнэ ХХК	Тендерт оролцогчийн үнийн санал баталсан төсвөөс зөрүүтэй, үнийн саналыг 47,430,000 төгрөг буюу баталсан төсвөөс 954,000 төгрөгөөр зөрүүтэй.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.





АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Х.ГАН-ОЧИР ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-мэйл: khuvs gul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: <http://umch.khs.gov.mn>

2019.02.19 № 1/69  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажлын зураг төсөл боловсруулах ХӨ-2019/1.3.1-зөвлөх-01 дугаартай төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад доор дурьдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтанд “Өрх” ХХК 29,000,000 төгрөгийн үнийн саналтай тендерийг ирүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажлын зураг төсөл боловсруулах ХӨ-2019/1.3.1-зөвлөх-01 дугаартай тендерт “Өрх” ХХК-ийн 29,000,000 (Хорин есөн сая) төгрөгөөр хийж гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн санал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.16 дахь заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажлын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай үнэлгээний хорооны шийдвэр, дүгнэлтийг хавсаргав.

ДАРГА



Б.БОЛД

271092100

dA/4



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Х.ГАН-ОЧИР ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-мэйл: khuvs gul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: <http://umch.khs.gov.mn>

2019.02.12 № 1/56  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Хөвсгөл аймгийн “Хөх сувд-2019” өвлийн аялал жуулчлалын эвент арга хэмжээний мөсөн урлан бүтээх ажлын гүйцэтгэгч сонгох ХӨ-2019/6.1.1 дугаартай тендер шалгаруулалтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянахад уг шийдвэр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Батлагдсан төсөв: 28 000 000 төгрөг

Санхүүжилтийн эх үүсвэр: Засаг даргын данс, мөсний баярт оролцох автомашины хураамж болон бусад эх үүсвэр

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох ХӨ-2019/6.1.1 дугаартай тендерийг 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 10 цаг 20 минутанд нээхэд “Их цэц бренд” ХХК 27 000 000 (Хорин долоон сая)төгрөгийн үнийн саналтай тендер ирүүлсэн байна. “Их цэц бренд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтын дагуу гэрээ байгуулах саналыг хүргүүлж байна.



ДАРГА

Б.БОЛД

d/A4  
00176047



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Х.ГАН-ОЧИР ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-мэйл: khuvsgul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: http://umch.khs.gov.mn

2019.02.12 № 1/55  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Модлог ургамлын үрийн төв тоног төхөөрөмжийн байр авах (контейнер), үрийн агуулахын дээвэр засварлах, зураг төсөл боловсруулах ХӨАОНӨГ/201912006/4.4.2 дугаартай төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурьдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтанд “Ногоон төгөл ой” ХХК 10,000,000 төгрөгийн үнийн саналтай тендерийг тус тус ирүүлсэн байна.

Модлог ургамлын үрийн төв тоног төхөөрөмжийн байр авах (контейнер), үрийн агуулахын дээвэр засварлах, зураг төсөл боловсруулах ажил нийлүүлэхээр “Ногоон төгөл ой” ХХК-ийн 10,000,000 (Арван сая) төгрөгийн үнийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Иймд “Ногоон төгөл ой” ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дэх заалтын дагуу гэрээ байгуулна уу.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6, Аймгийн ИТХ-ын 2013 оны 43 дугаар тогтоолын дагуу чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгааг гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

Зөвлөмжид үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулсан тухай үнэлгээний дүгнэлт, гэрээний төслийг хавсарган хүргүүлэв.

ДАРГА



Б.БОЛД

00176 0 5 d/A4

0716129361 4131053



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-мэйл: khuvs gul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: http://umch.khs.gov.mn

2019.02.19 № 1/51  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Ойжуулалтын ажил гүйцэтгэх ХӨАОНӨГ/201912003/4.4.3 дугаартай төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурьдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтанд “Ойн цэцэрлэг” ХХК 9,900,000 төгрөгийн үнийн саналтай тендерийг тус тус ирүүлсэн байна.

Ойжуулалтын ажил гүйцэтгэхээр “Ойн цэцэрлэг” ХХК-ийн 9,900,000 (Есөн сая есөн зуун мянган) төгрөгийн үнийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Иймд “Ойн цэцэрлэг” ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дэх заалтын дагуу гэрээ байгуулна уу.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6, Аймгийн ИТХ-ын 2013 оны 43 дугаар тогтоолын дагуу чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгааг гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

Зөвлөмжид үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулсан тухай үнэлгээний дүгнэлт, гэрээний төслийг хавсарган хүргүүлэв.

ДАРГА



Б.БОЛД

d/A4

001761029



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Х.ГАН-ОЧИР ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандеш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-мэйл: khuvs gul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: <http://umch.khs.gov.mn>

2019.02.11 № 1/МГ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжих Хөвсгөл аймгийн Рашаант, Шинэ-Идэр, Галт, Жаргалант, Цэцэрлэг, Цагаан-Уул, Арбулаг, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сумдын нэн ховор, ховор амьтны тархац нөөцийг нарийвчлан тогтоох, амьдрах орчны үнэлгээ өгөх судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурьдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтын дэлгэрэнгүй жагсаалтад “Агнуурсудлалын нийгэмлэг” ТББ, “Монголын анчдын нийгэмлэг” ТББ “Авралын эрэлд” ТББ, “Аргаль агнуур судлалын төв” ТББ -иудын мэдээлэл ирсэн бөгөөд эдгээр хүсэлт ирүүлсэн компаниудыг хураангуй жагсаалтад бүртгэж зөвлөх үйлчилгээний урилгыг хүргүүлсэн болно.

Хөвсгөл аймгийн Рашаант, Шинэ-Идэр, Галт, Жаргалант, Цэцэрлэг, Цагаан-Уул, Арбулаг, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сумдын нэн ховор, ховор амьтны тархац нөөцийг нарийвчлан тогтоох, амьдрах орчны үнэлгээ өгөх судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тендерт “Монголын анчдын нийгэмлэг” ТББ, “Агнуурсудлалын нийгэмлэг” ТББ тус тус тендерт оролцож санхүүгийн болон техникийн саналыг цахим системээр тус тус ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Рашаант, Шинэ-Идэр, Галт, Жаргалант, Цэцэрлэг, Цагаан-Уул, Арбулаг, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сумдын нэн ховор, ховор амьтны тархац нөөцийг нарийвчлан тогтоох, амьдрах орчны үнэлгээ өгөх судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Агнуурсудлалын нийгэмлэг” ТББ-ийн 12,192,000 (Арван хоёр сая нэг зуун ерэн хоёр мянган) төгрөгийн санхүүгийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.16 дахь заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

“Монголын анчдын нийгэмлэг” ТББ-ийн тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар

d/A4

001760027

зүйлийн 27.3 дахь заалтын дагуу шаардлагад нийцэж байгаа боловч шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендерийн үнийн саналаас 1,372,905 төгрөгөөр өндөр байгаа тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул татгалзав.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6, Аймгийн ИТХ-ын 2013 оны 43 дугаар тогтоолын дагуу чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгааг гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

Зөвлөмжид үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулсан тухай үнэлгээний дүгнэлт, гэрээний төслийг хавсарган хүргүүлэв.

ДАРГА



Б.БОЛД





**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар,  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: http://umch.khs.gov.mn

2018.02.02 № 1/45  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.БАЯНГОЛ ТАНАА

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн цай" нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАТЦСЗДТГ/201901021 дугаартай тендер шалгаруулалтай холбоотой "Тосон цахир" ХХК-ийн гаргасан гомдолтой танилцлаа.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар дээрх тендер шалгаруулалтад оролцсон компаниудын ирүүлсэн тендер болон худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийг хянан үзээд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1.Захиалагч Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захиргаа сурагчдын "Үдийн цай"-ны техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийг бүрэн хангаж, үнэлгээний хороонд ирүүлж хэвших.

2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч, үнэлгээний хорооны гишүүд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлж, Сангийн Сайдын 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшуулалтыг зохицуулах журам"-ыг баримтлан ажиллах

3. Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/17 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах" тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо тус сургуулийн 2019 оны "Үдийн цай" нийлүүлэх гүйцэтгэгч сонгох тендерийн багц-1( мах болон цагаан хоол)-д оролцсон "Тосон цахир" ХХК-ийн тендерийг 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр үнэлж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дэх заалтын дагуу татгалзсан шийдвэр, зөвлөмж үндэслэлтэй байгаа тул худалдан авах ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулах нь зүйтэй

4. 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 11 дугаартай албан бичгээр ирүүлсэн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн цай" нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАТЦСЗДТГ/201901021 дугаартай тендер шалгаруулалтай холбоотой тендерийн баримт бичгийг хүргүүлж байна.

Үүнд: Баримт-1 201 хуудас, баримт-2 152 хуудас, баримт-3 279 хуудас нийт 632 хуудас материал хүргүүлэв.

ДАРГА



Б.БОЛД

d/A4

001760021



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.  
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848  
Э-мэйл: khuvs gul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: <http://umch.khs.gov.mn>

2019.02.01 № 1/43  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгөөр санхүүжих туулах чадвар сайтай авто машин нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/2019812009/4.3.1 дугаартай төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад доор дурьдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтанд “Их харгана ундраа” ХХК 49,500,000 төгрөгийн, “Хөвсгөл Галт” ХХК 49,800,000 төгрөгийн, “Жигүүр ой” ХХК 47,500,000 төгрөгийн үнийн саналтай тендерүүдийг тус тус ирүүлсэн байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгөөр санхүүжих туулах чадвар сайтай авто машин нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/2019812009/4.3.1 дугаартай тендерт “Их харгана ундраа” ХХК-ийн 49,500,000 (Дөчин есөн сая таван зуун мянган) төгрөгөөр хийж гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн санал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

“Хөвсгөл Галт” ХХК-ийн ирүүлсэн үнийн санал нь ТӨӨЗ-н 3.1.3, ТӨӨЗ-н 5.2-ын 10, ТӨӨЗ-н 3.1 дахь заалтуудыг хангахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалтыг хангахгүй байгаа тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

“Жигүүр ой” ХХК-ийн ирүүлсэн үнийн санал нь ТӨӨЗ-н 3.1, ТӨӨЗ-н 3.1-2.1, ТӨӨЗ-н 3.1-2 дахь заалтуудын тус тус хангахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалтыг хангахгүй байгаа тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар

зүйлийн 43.6, Аймгийн ИТХ-ын 2013 оны 43 дугаар тогтоолын дагуу чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгааг гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

Автомашин нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай үнэлгээний хорооны шийдвэр, дүгнэлтийг хавсаргав.

ДАРГА



Б.БОЛД